



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/644

Хэрлэн сум

Аймгийн “Оны шилдэг”-ийн шагналд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2015 оны А/562 дугаар захирамжаар баталсан “Оны шилдэг ажилтан, байгууллага” шалгаруулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны шилдэг ажилтан, байгууллагын шагналд 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 18-ны
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Зардалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Оны шилдэг ажилтны шагнал	8	500000	4000000
2	Оны шилдэг байгууллагын шагнал	2	100000	2000000
3	Оны шилдэг залуу шагнал	8	200000	1600000
4	Шилдэг залуучуудын зөвлөл шагнал	1	1000000	1000000
5	Оны шилдэгийн цом	26	80000	2080000
6	Оны шилдэг байгууллагын өргөмжлөл	4	90000	320000
Нийт дүн				11000000